

ЭРХЭМ ХҮНДЭТ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Бангкок, 2020 оны 1 дүгээр сарын 20

**Монгол улсад Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг
батлан хэрэгжүүлэхэд дэмжлэг хүсэх тухай**

Эрхэм хүндэт ноён, Ухнаагийн Хүрэлсүх танаа

Ази тивийн 21 улсад 81 гишүүн байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн Форум (ФОРУМ-АЗИ) байгууллагын нэрийн өмнөөс танд хандан хүний эрхийн хамгаалагч (ХЭХ)-ийн эрх зүйн байдлын тухай хуулийг Монгол улсад батлан хэрэгжүүлэхийн ач холбогдолд анхаарал хандуулахыг хүсч энэхүү нээлттэй захиаг бичиж байна.

Хуулийн хүрээнд, тайван замаар хэрэгжүүлж буй хүний эрхийн ажлаасаа болж эрсдэлд учирч байгаа ХЭХ-ийг үндэсний эрх зүйн хүрээнд хамгаалах нь нэн чухал. Ази тивд хүний эрхийн төлөө хийж байгаа ажлынхаа төлөө ХЭХ-чид төрөл бүрийн хэлбэрийн хүчирхийлэлд байнга өртөж байна. ФОРУМ-АЗИ байгууллагын баримтжуулснаар 2017-2019 оны хооронд ХЭХ-ийн эсрэг 1,014 халдлага үйлдсэнээс 78-д нь ХЭХ амь насаа алдсан байна.¹ Гэхдээ энэ тоо бодит байдалд гарч байгаа халдлага, хүчирхийллийн зөвхөн цөөн илэрсэн хэсэг нь юм. Ялангуяа, алслагдсан нутагт байгаль орчин, нутгийн иргэдийн эрхийг хамгаалахаар ажилладаг ХЭХ-чид онцгой эмзэг бөгөөд тэдний эсрэг үйлдсэн халдлагуудын тухай тоо баримт бодит байдлаас бүүр ч доогуур байдаг.

Монгол улсыг ХЭХ ажиллахад харьцангуй аюулгүй улс гэж үздэг.² Гэхдээ НҮБ-ын ХЭХ-ийн асуудлаарх тусгай илтгэгч Майкл Форст 2019 онд хийсэн айлчлалынхаа тухай мэдэгдэлд байгаль орчин, бэлгийн цөөнхийн эсрэг ялгаварлан гадуурхалт, авилгын асуудлаар бичдэг сэтгүүлчид зэрэг ХЭХ-дын эсрэг нэр хоч өгөх, доромжлох, гүтгэх, заналхийлэх, сүрдүүлэх, хүчирхийлэх зэрэг үйлдэл гарсаар байгааг тэмдэглэжээ.

Үүний тод жишээ нь 2014 онд С.Анхбаяр, Н.Мөнхтөр нар орон нутгийн төрийн захиргааны удирдлага, улс төрчдийг шүүмжилсний төлөө нэр төр гутаасан хэрэгт татагдсан, 2015 онд байгаль хамгаалагч Төмөрсүхийн Лхагвасүрэн сэжигтэйгээр амь насаа алдсан, 2018 онд орон нутгийн ХЭХ эмэгтэй Д.Мөнгөнхун бие махбодийн болон бэлгийн халдлаганд өртсөн зэрэг хэрэг болно.³

Хэдийгээр Монгол улсын зарим хууль, журмуудыг ХЭХ-дыг хамгаалахад ашиглаж болох ч орон нутагтаа хүний эрхийн төлөө ажилладаг ХЭХ-ийг хамгаалах үр дүнтэй эрхзүйн хамгаалалт байхгүй байгаа нь тэдний сэтгэлийг хамгийн их зовоож байна.⁴ Энэ нь ХЭХ-чдыг хүлээн

¹ ФОРУМ-АЗИ байгууллагын Ази тивийн ХЭХ-ийн эсрэг хүчирхийллийг бүртгэсэн мэдээллийг (англи хэл дээр) дараах линкээс авч болно: <https://asianhrds.forum-asia.org/en/library/>

² НҮБ. (2019). Монгол Улс: НҮБ-ын эксперт Монгол улсыг иргэний нийгмийн орон зайг хумих, хуульт ёсноос ухрах нь гэж анхааруулж байна.

<https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=24604>

³ ФОРУМ-АЗИ. (2019). Бидний нутаг: Монгол улсын Хэнтий Дорнод аймгууд дахь хүний эрхийн хамгаалагчдад уул уурхайн үзүүлж буй нөлөөллийг баримтжуулах зорилготой томилолтын тайлан. Хуудас 38, 46. <https://www.forum-asia.org/uploads/wp/2019/10/FFM-Mongolia-2019-Report.pdf>

⁴ ФОРУМ-АЗИ (2015). Хүний эрхийн зөвлөлийн аман мэдэгдэл - Монгол улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг. илтгэлийг харах линк: <https://www.forum-asia.org/?p=19529>
Монгол улсын ХЭХ-ийн асуудлаарх үндэсний зөвлөгөөний 2015, 2018 оны мэдэгдлүүдийг харах линк:

зөвшөөрч, хамгаалах баталгаа өгөх зорилготой ХЭХ-ийн эрх зүйн байдлын тухай цогц шийдлийг багтаасан шинэ хуулийг батлан хэрэгжүүлэх чухал хэрэгцээ байгааг харуулж байна. Энэ хууль нь эмзэг бүлгүүдийн ХЭХ-ийг хамгаалах хэрэгцээг ч тусгах шаардлагатай.

Иргэний нийгмийн сүлжээнүүд, ХЭХ-д, судлаачид, Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), болон засгийн газрын бусад гол оролцогч тал болох Гадаад харидцааны яам нь ХЭХ-ийн тухай хууль батлуулахын төлөө олон жил шаардаж шургуу ажилласаар ирсэн.

НҮБ-ын тусгай илтгэгч Мишель Форст ч бас ХЭХ-ийн хуулийг батлах нь ХЭХ-дын хийж буй хууль ёсны амин чухал ажлыг хүлээн зөвшөөрч, дэмжих чухал алхам болохыг онцлон хэлсэн байдаг. Энэ хуулийг баталснаар ХЭХ-дыг төрийн болон төрийн бус бусад талуудын хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалалт болох юм.

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан, ФОРУМ-АЗИ-ийн зүгээс үндэсний эрхзүйн хүрээнд ХЭХ-ийг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө хуулийн төсөлд холбогдох талуудын саналыг тусган ажилласан бүх талуудын хүчин чармайлтад талархаж байна.

Гэсэн хэдий ч дараачийн алхамыг нэн яаралтай хийх шаардлагатай байна. Ардчиллаараа Азид тэргүүлдэг, олон улсын хамтын нийгэмлэгийн чухал гишүүн Монгол улсын ХЭХ-ийн хуулийг батлах тухай албан ёсны амлалт нь хүний эрхийн төлөө ажиллаж буй ХЭХ-ийн зайлшгүй хийдэг ажил, үүргийг хүлээн зөвшөөрөхийн ач холбогдол болон тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ), зорилтуудыг хэрэгжүүлэх тулгуур болох тухай дэлхий даяар түгээх хүчтэй дохио болох юм.

Хүний эрхийн бүсийн дуу хоолой болох ФОРУМ-АЗИ нь Монгол улсын Ерөнхий сайд танаас ХЭХ-дыг эрхзүйн хамгаалалтаар хангахын ач холбогдол болон хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөхийг хүсч байна. Түүнчлэн ХЭХ-ийн тухай хууль нь цогц, үр дүнтэй хамгаалалт үзүүлэх, хүчирхийлэгчидтэй хариуцлага тооцох зохицуулалтуудыг агуулах баталгааг хангаж ажиллахыг хүсч байна. Ерөнхий сайдын ажлын албыг уг хуулийг батлуулахад шаардлагатай алхмуудыг хийж, манлайлж ажиллахыг мөн хүсч байна.

Бид өнгөрсөн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас дэвшилтэт хуулиудыг батлан хэрэгжүүлэхэд гаргасан тууштай хүчин чармайлтыг сайшааж байна. ХЭХ-ийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлах нь эдгээр хүчин чармайлтуудын зүй ёсны үргэлжлэл юм. ФОРУМ-АЗИ, Монгол дахь гишүүн байгууллагуудынхаа хамт ХЭХ-ийн эрхзүйн байдлын тухай хуулийг батлуулахад дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлж байна.

Энэ асуудалд анхаарлаа хандуулсан Танд баярлалаа. Бид шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах бүрэн боломжтой.

Хүндэтгэсэн,



Мукунда Катте
ФОРУМ-АЗИ-ийн Гүйцэтгэх захирал

<https://www.forum-asia.org/?p=19354> and <https://www.forum-asia.org/?p=27678>